



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 08 өдөр

Дугаар Н/153

Шивээговь сум

Сумын “Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах-Хоггүй сум” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 271 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны “Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих сумын “Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах - Хоггүй сум” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, здийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Э.Баярмагнай (Газрын даамал)

О.Отгонбаяр (Байгаль хамгаалагч)

С.Отгонбаатар (2 дугаар багийн Засаг дарга)

2. Дээрх хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ



421210589